



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn


2024. 05. 24 № 1/2740
танай 2024. 06. 11-ны № 1/1993-т

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАН
ТАНАА

Улсын нэгдсэн бүртгэлд
бүртгэсэн тухай

"Журам шинэчлэн батлах тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн A/178, A/238, A/173 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн6836..... дугаарт бүртгэж хүргүүлэв.

Түүнчлэн дээрх хамтарсан тушаалыг баталсантай холбогдуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 5786 дугаарт бүртгэлтэй Шадар сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 28/A/108/A/180 дугаар тушаалыг хүчингүй болгох арга хэмжээ авч, улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөн хийлгэнэ үү.



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн буртгэлд
2024 оны 05 сарын 24-ны
одийн 6836 дугаарт бүртгэв.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар №178... №188... №179

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
- Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Боловсролын ерөнхий газар, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газарт тус тус даалгасугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус даалгасугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Х.БОЛОРЧУЛУУН

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

С.ЧИНЗОРИГ

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дугаар
сарын 16 -ны өдрийн A/198, A/198, A/193
дугаар хамтарсан тушаалын хавсралт

СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь ерөнхий боловсролын сургууль түүний дотуур байрын /цаашид сургууль гэх/ хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, зөвлөн туслах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх замаар суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хоол, хүнсний үйлчилгээг хүргэж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2. Өмчийн бүх хэлбэрийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд энэхүү журмыг мөрднө.

1.3. Энэхүү журмын зохицуулалтад холбогдох төрийн захиргааны байгууллага, тухайн шатны Засаг дарга, орон нутгийн боловсрол, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн газар хамтран сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түүний орчин, аюулгүй байдалд хяналт, үнэлгээ хийх, удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиг үүрэг, тайлагналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хамаарна.

1.4. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт, үнэлгээнд төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, судалгааны байгууллага, судлаач, иргэдийн төлөөллийг татан оролцуулж болно.

1.5. Энэхүү журмын зохицуулалтаас гадна сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд орон тооны бус “Хяналтын зөвлөл”, байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Боловсрол, хүнс, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, салбар дундын ажлын уялдааг хангаж ажиллана.

2.1.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал

үүслийн баталгаажилтад хяналт тавих, тогтвортой ханган нийлүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

2.1.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдалд үнэлгээ хийх, үр дүнг мэдээлж, зөвлөмж, мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

2.1.4. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт, үнэлгээний дүнд үндэслэн хүнсний сүлжээнд зохистой дадлыг нэвтрүүлэх сургалтыг жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хамтран зохион байгуулна.

2.1.5. Хүнс болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын тайланг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнан ажиллана.

2.1.6. Хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /боловсрол, хүнс, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын салбарын хяналт/-аас Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ энэхүү хяналт, үнэлгээг хамтран төлөвлөж, зохион байгуулж болно.

2.1.7. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хяналт, үнэлгээний дүнд үндэслэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг хангахад салбар дундын бодлогын уялдаа холбоог хангасан төлөвлөлт, шийдлийг гаргаж ажиллана.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавих, энэхүү журмын 2.3.1-д заасан хяналт, үнэлгээг хэрэгжүүлэх, орон нутгийн салбар дундын зохион байгуулалтыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.

2.2.2. Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого, удирдлага зохион байгуулалт, хэрэгжилтийг ханган ажиллах төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангасан орон тооны бус “Хүүхдийн хоолны зөвлөл”-ийг байгуулж, ахалж ажиллана.

2.2.3. Энэхүү журмын хүрээнд хийгдсэн хяналт, үнэлгээний дүнг 2.2.2-т заасан зөвлөлөөр хэлэлцүүлэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг жигд, тогтвортой зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв санхүүжилтийг шийдвэрлэхэд дэмжилгээг үзүүлж ажиллана.

2.2.4. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хоршоодын үйл ажиллагааг дэмжих чадавжуулах, хүүхдийн хоол, хүнсний хангамжид гарал үүслийн болон тохирлын баталгаатай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлсэн тогтвортой худалдан авалт, ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, гүйцэтгэл, үр дүнг хянана.

2.2.5. Сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгаа, орчны үнэлгээ, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангуулахад хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж, гүйцэтгэл үр дүнг хянана.

2.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, хоол, хүнсний хангамж, хүртээмж, чанар аюулгүй байдлын хяналт, үнэлгээг холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулж, тайланг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.3.2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт, үнэлгээний аргачлал боловсруулан баталж, орон нутгийн байгууллагыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

2.3.3. Журмын 2.3.1-д заасан хяналт, үнэлгээг дараах чиглэлийг баримтлан хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.3.1. сургуулийн хоол үйлдвэрлэлийн байрны орчин нөхцөл, стандартын хэрэгжилт;

2.3.3.2. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, гарал үүсэл, баталгаажилт, тээвэрлэлт шаардлага хангаж буй эсэх;

2.3.3.3. хүнс ханганд нийлүүлэгчтэй хийсэн гэрээний хэрэгжилт;

2.3.3.4. нэг хүүхдэд ногдох үдийн хоолны норматив зардлын зарцуулалт, хоолны цэс төлөвлөлт, хоолны орц, шим тэжээл, чанар, аюулгүй байдал, эрүүл ахуй;

2.3.3.5. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх холбогдох дүрэм журам, шийдвэр болон "Хандив, тусламжийг хүлээн авах ажлыг зохион байгуулах журам", "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус Хяналтын зөвлөлийн ажиллах журам", "Сургалтын байгууллагын хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам", дотоод хяналтын хэрэгжилт;

2.3.3.6. усан хангамж, шүүлтүүртэй цэвэр усны хүрэлцээ;

2.3.3.7. мэргэжлийн хүний нөөц (хоол зүйч, хүүхдийн хоолны чиглэлээр мэргэшсэн тогооч)-өөр хангагдсан байдал, ур чадвар, түвшин;

2.3.3.8. хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал, хүрэлцээ, хүчин чадалд тохирсон эсэх;

2.3.3.9. суралцагчдад эрүүл мэнд, хоол шим тэжээлийн талаар боловсрол олгож байгаа байдал;

2.3.3.10. сургуулийн орчинд хүүхдэд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний байдал;

2.3.11. ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, зохион байгуулалт.

2.3.4. Энэхүү журмын 2.3.3-т зааснаас гадна дараах чиглэлээр хяналт, үнэлгээ хийнэ. Үүнд:

2.3.4.1. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт;

2.3.4.2. сургуулийн орчин дахь хоол шим тэжээлийн байдал, эрүүл бус хүнсний зар сурталчилгаа, нэлөөлөл;

2.3.4.3. хуульд заасан бусад чиг үүрэг.

2.3.5. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

2.3.6. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хяналт, үнэлгээний мэдээллийн сан үүсгэж, хөгжүүлнэ.

2.3.7. Холбогдох хууль тогтоомж, шийдвэр, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт мэдээлэл, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.4. Аймаг, нийслэлийн боловсрол, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн газар доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1. Журмын 2.3.1-т заасан хяналт, үнэлгээг хамтран хийж, санал дүгнэлтийг нэгтгэн 2.2.2-т заасан зөвлөлд танилцуулан хэлэлцүүлж, дүн танилцуулга, шийдвэрийг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.4.2. Хяналт, үнэлгээний явцад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, дээд шатны байгууллагад мэдэгдэнэ.

2.4.3. Сургуулийн удирдлага, холбогдох ажилтан, суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хоол, хүнсний зөв зохистой хэрэглээ, эрүүл, аюулгүй хүнсний талаарх зөвлөмж мэдээллийг тогтмол өгч, сургалт сурталчилгааг хамтран зохион байгуулна.

2.4.4. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хоол, хүнснээс шалтгаалсан байнгын болон өвчлөлийн үеийн тандалт судалгааг хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, холбогдох байгууллагад үр дүнг мэдээлнэ.

2.4.5. Сургуулийн хүүхдэд олгож буй хоол хүнсэнд хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтэд шаардлагатай шим тэжээл, амин дэм, илчлэгийн норм хэмжээг хангуулахад зөвлөмж мэдээллээр хангана.

2.4.6. Журмын 2.2.2-т заасан "Хүүхдийн хоолны зөвлөл"-ийг мэргэжил арга зүй, мэдээллээр хантаж ажиллана.

2.4.8. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Гурав. Бусад

3.1. Төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрсдэлийн үнэлгээний дүн, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын мэдээллийг жил бүрийн 12 дугаар сард багтаан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж хамtran ажиллана.

3.2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдварын үед холбогдох тушаал, дүрэм, журмыг удирдлага болгон мэдээллийг шуурхай солилцож хамtran ажиллана.

3.3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаарх боловсролын үйлчилгээнд оролцогч талууд болон олон нийтэд чиглэсэн зөвлөн туслах, сургалт сурталчилгааны ажлыг хамtran зохион байгуулна.

3.4. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбарын хэмжээнд дотоод хяналтыг төлөвлөн хэрэгжүүлж болно.

3.5. Энэхүү журмын хүрээнд хяналт тавих байгууллагууд нь төлөвлөлт, зохион байгуулалтын уялдаа холбоог хангаж ажиллана.

Дөрөв. Хариуцлага

4.1. Хяналт, үнэлгээний дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлт нь тухайн сургуулийн үнэлгээг дүгнэхэд харгалзан үзэх үндэслэл болно.

4.2. Энэхүү журмыг мөрдөж ажиллаагүй хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

..... ooOoo

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 05 сарын 24-ны
одийн 6136 дугаарт бүртгэв.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 04 сарын 16-өдөр

Дугаар .../.../...

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
- Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Боловсролын ерөнхий газар, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газарт тус тус даалгасугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус даалгасугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД


Л.ЭНХ-АМГАЛАН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Х.БОЛОРЧУЛУУН

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

С.ЧИНЗОРИГ



Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 07 дугаар
сарын 16.. -ны өдрийн 01/148, 01/238, 01/133
дугаар

хамтарсан тушаалын хавсралт

СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь ерөнхий боловсролын сургууль түүний дотуур байрын /цаашид сургууль гэх/ хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, зөвлөн туслах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх замаар суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хоол, хүнсний үйлчилгээг хүргэж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2. Өмчийн бүх хэлбэрийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Энэхүү журмын зохицуулалтад холбогдох төрийн захиргааны байгууллага, тухайн шатны Засаг дарга, орон нутгийн боловсрол, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн газар хамtran сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түүний орчин, аюулгүй байдалд хяналт, үнэлгээ хийх, удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиг үүрэг, тайлagnалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хамаарна.

1.4. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт, үнэлгээнд төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, судалгааны байгууллага, судлаач, иргэдийн төлөөллийг татан оролцуулж болно.

1.5. Энэхүү журмын зохицуулалтаас гадна сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд орон тооны бус "Хяналтын зөвлөл", байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Боловсрол, хүнс, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, салбар дундын ажлын уялдааг хангаж ажиллана.

2.1.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал

үүслийн баталгаажилтад хяналт тавих, тогтвортой ханган нийлүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

2.1.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдалд үнэлгээ хийх, үр дүнг мэдээлж, зөвлөмж, мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

2.1.4. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт, үнэлгээний дунд үндэслэн хүнсний сүлжээнд зохистой дадлыг нэвтрүүлэх сургалтыг жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хамтран зохион байгуулна.

2.1.5. Хүнс болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын тайланг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнан ажиллана.

2.1.6. Хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /боловсрол, хүнс, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын салбарын хяналт/-аас Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ энэхүү хяналт, үнэлгээг хамтран төлөвлөж, зохион байгуулж болно.

2.1.7. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хяналт, үнэлгээний дунд үндэслэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг хангахад салбар дундын бодлогын уялдаа холбоог хангасан төлөвлөлт, шийдлийг гаргаж ажиллана.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавих, энэхүү журмын 2.3.1-д заасан хяналт, үнэлгээг хэрэгжүүлэх, орон нутгийн салбар дундын зохион байгуулалтыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.

2.2.2. Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого, удирдлага зохион байгуулалт, хэрэгжилтийг ханган ажиллах төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангасан орон тооны бус "Хүүхдийн хоолны зөвлөл"-ийг байгуулж, ахалж ажиллана.

2.2.3. Энэхүү журмын хүрээнд хийгдсэн хяналт, үнэлгээний дунг 2.2.2-т заасан зөвлөлөөр хэлэлцүүлэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг жигд, тогтвортой зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв санхүүжилтийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

2.2.4. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хоршоодын үйл ажиллагааг дэмжиж чадавхжуулах, хүүхдийн хоол, хүнсний хангамжид гарал үүслийн болон тохирлын баталгаатай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлсэн тогтвортой худалдан авалт, ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, гүйцэтгэл, үр дүнг хянана.

2.2.5. Сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгаа, орчны үнэлгээ, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангуулахад хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж, гүйцэтгэл үр дүнг хянана.

2.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, хоол, хүнсний хангамж, хүртээмж, чанар аюулгүй байдлын хяналт, үнэлгээг холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулж, тайланг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.3.2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт, үнэлгээний аргачлал боловсруулан баталж, орон нутгийн байгууллагыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

2.3.3. Журмын 2.3.1-д заасан хяналт, үнэлгээг дараах чиглэлийг баримтлан хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.3.1. сургуулийн хоол үйлдвэрлэлийн байрны орчин нөхцөл, стандартын хэрэгжилт;

2.3.3.2. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, гарал үүсэл, баталгаажилт, тээвэрлэлт шаардлага хангаж буй эсэх;

2.3.3.3. хүнс ханган нийлүүлэгчтэй хийсэн гэрээний хэрэгжилт;

2.3.3.4. нэг хүүхдэд ногдох үдийн хоолны норматив зардлын зарцуулалт, хоолны цэс төлөвлөлт, хоолны орц, шим тэжээл, чанар, аюулгүй байдал, эрүүл ахуй;

2.3.3.5. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх холбогдох дүрэм журам, шийдвэр болон "Хандив, тусlamжийг хүлээн авах ажлыг зохион байгуулах журам", "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус Хяналтын зөвлөлийн ажиллах журам", "Сургалтын байгууллагын хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам", дотоод хяналтын хэрэгжилт;

2.3.3.6. усан хангамж, шүүлтүүртэй цэвэр усны хүрэлцээ;

2.3.3.7. мэргэжлийн хүний нөөц (хоол зүйч, хүүхдийн хоолны чиглэлээр мэргэшсэн тогооч)-вөр хангагдсан байдал, ур чадвар, түвшин;

2.3.3.8. хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал, хүрэлцээ, хүчин чадалд тохирсон эсэх;

2.3.3.9. суралцаагчдад эрүүл мэнд, хоол шим тэжээлийн талаар боловсрол олгож байгаа байдал;

2.3.3.10. сургуулийн орчинд хүүхдэд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний байдал;

2.3.11. ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, зохион байгуулалт.

2.3.4. Энэхүү журмын 2.3.3-т зааснаас гадна дараах чиглэлээр хяналт, үнэлгээ хийнэ. Үүнд:

2.3.4.1. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт;

2.3.4.2. сургуулийн орчин дахь хоол шим тэжээлийн байдал, эрүүл бус хүнсний зар сурталчилгаа, нөлөөлөл;

2.3.4.3. хуульд заасан бусад чиг үүрэг.

2.3.5. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

2.3.6. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хяналт, үнэлгээний мэдээллийн сан үүсгэж, хөгжүүлнэ.

2.3.7. Холбогдох хууль тогтоомж, шийдвэр, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт мэдээлэл, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.4. Аймаг, нийслэлийн боловсрол, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн газар доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1. Журмын 2.3.1-т заасан хяналт, үнэлгээг хамтран хийж, санал дүгнэлтийг нэгтгэн 2.2.2-т заасан зөвлөлд танилцуулан хэлэлцүүлж, дүн танилцуулга, шийдвэрийг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.4.2. Хяналт, үнэлгээний явцад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, дээд шатны байгууллагад мэдэгдэнэ.

2.4.3. Сургуулийн удирдлага, холбогдох ажилтан, суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хоол, хүнсний зөв зохистой хэрэглээ, эрүүл, аюулгүй хүнсний талаарх зөвлөмж мэдээллийг тоогтол өгч, сургалт сурталчилгааг хамтран зохион байгуулна.

2.4.4. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хоол, хүнснээс шалтгаалсан байнгын болон өвчлөлийн үеийн тандалт судалгааг хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, холбогдох байгууллагад үр дүнг мэдээлнэ.

2.4.5. Сургуулийн хүүхдэд олгож буй хоол хүнсэнд хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтед шаардлагатай шим тэжээл, амин дэм, илчлэгийн норм хэмжээг хангуулахад зөвлөмж мэдээллээр хангана.

2.4.6. Журмын 2.2.2-т заасан “Хүүхдийн хоолны зөвлөл”-ийг мэргэжил арга зүй, мэдээллээр хангаж ажиллана.

2.4.8. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Гурав. Бусад

3.1. Төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрсдэлийн үнэлгээний дүн, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын мэдээллийг жил бүрийн 12 дугаар сард багтаан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж хамtran ажиллана.

3.2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдварьн үед холбогдох тушаал, дүрэм, журмыг удирдлага болгон мэдээллийг шуурхай солилцож хамtran ажиллана.

3.3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаарх боловсролын үйлчилгээнд оролцогч талууд болон олон нийтэд чиглэсэн зөвлөн туслах, сургалт сурталчилгааны ажлыг хамtran зохион байгуулна.

3.4. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбарын хэмжээнд дотоод хяналтыг төлөвлөн хэрэгжүүлж болно.

3.5. Энэхүү журмын хүрээнд хяналт тавих байгууллагууд нь төлөвлөлт, зохион байгуулалтын уялдаа холбоог хангаж ажиллана.

Дөрөв. Хариуцлага

4.1. Хяналт, үнэлгээний дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлт нь тухайн сургуулийн үнэлгээг дүгнэхэд харгалзан үзэх үндэслэл болно.

4.2. Энэхүү журмыг мөрдөж ажиллаагүй хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

..... ooOoo